



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/М

Улаанбаатар хот

Гэрээ сунгаж ажиллуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3.1.4, 3 дугаар хэсгийн 3.1.15, 3.1.16, Нийслэлийн засаг даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэл, 2018 оны 12 дугаар сарын 31-ний ажил дүгнэх хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Айл өрх аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгуулах ажлыг хэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахаар Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ-тай байгуулсан 18/06-226 дугаар гэрээг сунгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Айл өрх аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгуулах ажлыг хэвшүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай 200 000 000 / хоёр зуун сая / төгрөгийг хог хаягдал ангилан ялгах зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

